

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЖАРГАЛАНТ СУМЫН 13 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/ 98/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh
@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг:
Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрэл Хөхийн тэнцвэр аудит ХХК

Аудитор: Д.Хишгээ

Утас: 99964238 Цахим хаяг: Hishgee.Da@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	8
3.1. Ерөнхий зүйл	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт	13
Залруулсан алдаа	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ. ДҮГНЭЛТ

 ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 84000 Цамбагараа баг, Жаргалант сум, Ховд Утас: 976-70433081, Факс: 976-70433081 E-mail: khovd@audit.gov.mn	ЖАРГАЛАНТ СУМЫН 13 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ОЮУНЧИМЭГ ТАНАА
2021.04.25 № 4/88 танай _____ -ны № _____ -г	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.	
Дүгнэлтийн үндэслэл	
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.	
Бусад мэдээлэл	
Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, сургуулийн өмнөх боловсрол хэрэгжилт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.	

101000031

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>37 611 703.91</u>	<u>45 237 791.91</u>
33	АВЛАГА	36 044.00	44.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	36 044.00	44.00
35	БАРАА МАТЕРИАЛ	37 575 659.91	45 237 747.91
351	Түүхий эд материал	-	1 493 040.00
35130	Эм боох материал	-	1 493 040.00
354	Хангамжийн материал	37 575 659.91	43 744 707.91
35410	Бичиг хэргийн материал	319 310.00	662 310.00
35420	Аж ахуйн материал	-	94 850.00
35450	Барилгын засварын материал	-	4 235 000.00
35460	Хүнсний материал	363 539.00	447 237.00
35470	Бусад хангамжийн материал	36 892 810.91	38 305 310.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>740 583 211.30</u>	<u>721 218 953.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	740 583 211.30	721 218 953.16
392	Биет хөрөнгө	655 397 336.30	636 197 328.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	620 915 148.13	620 915 148.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2 072 288.00)	(35 480 865.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35 458 858.93	39 857 858.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21 358 709.00)	(28 060 633.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32 139 895.24	32 839 895.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9 685 569.00)	(13 390 975.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	22 016 900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(2 499 999.96)
393	Биет бус хөрөнгө	85 185 875.00	85 021 624.90
39301	Програм хангамж	1 337 000.00	1 337 000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(807 125.00)	(971 375.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	84 656 000.00	84 656 000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>778 194 915.21</u>	<u>766 456 745.07</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>778 194 915.21</u>	<u>766 456 745.07</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	778 194 915.21	766 456 745.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	84 656 000.00	84 656 000.00
51101	Өмч: - төрийн	84 656 000.00	84 656 000.00
512	Хуримтлагдсан үр дүн	454 550 332.38	442 812 162.24
51210	Өмнөх үеийн үр дүн	454 550 332.38	438 882 187.58
51220	Тайлант үеийн үр дүн	-	3 929 974.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	238 988 582.83	238 988 582.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>778 194 915.21</u>	<u>766 456 745.07</u>

2.3 АУДИТ ХИЙСЭН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339 914 001.4	390 577 800.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6 070 978.4	26 963 400.0
120	Нийтлэг татварын бус орлого	6 070 978.4	26 963 400.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5 670 978.4	26 963 400.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5 670 978.4	26 963 400.0
120009	Бусад орлого	400 000.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	333 843 023.0	363 614 400.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	328 685 600.0	333 412 200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26 994 100.0	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	301 691 500.0	333 412 200.0

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	30 202 200.0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	30 202 200.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5 157 423.0	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5 157 423.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	351 114 815.1	386 647 825.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	351 114 815.1	386 647 825.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343 774 024.1	371 269 262.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224 436 752.0	261 997 904.6
210101	Үндсэн цалин	220 886 508.0	261 997 904.6
210102	Нэмэгдэл	50 000.0	-
210104	Урамшуулал	3 500 244.0	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28 698 067.0	33 438 514.2
210201	Тэтгэврийн даатгал	19 598 508.0	33 001 714.2
210202	Тэтгэмжийн даатгал	2 658 783.0	436 800.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 638 443.0	-
210204	Ажилгүйдлийн даатгал	436 576.0	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4 365 757.0	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21 254 156.0	18 892 580.0
210301	Гэрэл, цахилгаан	16 977 356.0	15 379 380.0
210303	Цэвэр, бохир ус	4 276 800.0	3 513 200.0
2104	Хангамж, бараа материалын зардал	695 070.0	356 000.0
210401	Бичиг хэрэг	325 970.0	123 000.0
210402	Тээвэр, шатахуун	160 200.0	61 700.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	111 200.0	101 000.0
210404	Ном, хэвлэл	97 700.0	70 300.0
2105	Нормативт зардал	48 800 695.7	20 616 250.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	195 700.0	1 286 177.0
210502	Хоол, хүнс	47 853 413.7	18 379 566.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	751 582.0	950 507.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5 199 200.3	3 678 400.0
210604	Урсгал засвар	5 199 200.3	3 678 400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432 000.0	544 000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	112 000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432 000.0	432 000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14 258 083.2	31 745 613.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 099 400.0	933 600.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13 158 683.2	30 812 013.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7 340 791.0	15 378 563.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	5 557 423.0	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5 157 423.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400 000.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15 378 563.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15 378 563.3
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1 783 368.0	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1 783 368.0	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11 200 813.8)	3 929 974.7

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	334 243 023.0	363 614 400.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400 000.0	-
120	Нийтлэг татварын бус орлого	400 000.0	-
120009	Бусад орлого	400 000.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	333 843 023.0	363 614 400.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	328 685 600.0	333 412 200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26 994 100.0	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	301 691 500.0	333 412 200.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	30 202 200.0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	30 202 200.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5 157 423.0	-

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5 157 423.0	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	334 243 023.0	363 614 400.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	334 243 023.0	363 614 400.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326 902 232.0	348 235 836.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224 866 232.0	260 593 418.7
210101	Үндсэн цалин	172 478 244.0	176 712 830.7
210102	Нэмэгдэл	38 274 288.0	57 648 868.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4 438 793.0
210104	Урамшуулал	14 113 700.0	21 792 927.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28 331 300.0	34 843 000.0
210201	Тэтгэврийн даатгал	19 265 300.0	24 414 800.0
210202	Тэтгэмжийн даатгал	2 266 600.0	2 607 100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 813 200.0	2 085 700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	453 300.0	521 400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4 532 900.0	5 214 000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21 254 200.0	23 062 580.0
210301	Гэрэл, цахилгаан	16 977 400.0	19 549 380.0
210303	Цэвэр, бохир ус	4 276 800.0	3 513 200.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1 082 900.0	631 000.0
210401	Бичиг хэрэг	169 800.0	123 000.0
210402	Тээвэр, шатахуун	160 200.0	61 700.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	111 200.0	152 000.0
210404	Ном, хэвлэл	97 700.0	70 300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	544 000.0	224 000.0
2105	Нормативт зардал	44 571 800.0	22 952 838.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65 900.0	3 485 874.0
210502	Хоол, хүнс	43 912 500.0	18 463 264.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	593 400.0	1 003 700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5 199 200.0	4 643 400.0
210604	Урсгал засвар	5 199 200.0	4 643 400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432 000.0	544 000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	112 000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432 000.0	432 000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 164 600.0	965 600.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 164 600.0	965 600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7 340 791.0	15 378 563.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	5 557 423.0	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5 157 423.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400 000.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15 378 563.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15 378 563.3
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1 783 368.0	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1 783 368.0	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	84 656 000.00	238 988 582.83	454 550 332.38	778 194 915.21
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	84 656 000.00	283 988 582.83	454 550 332.38	823 194 915.21
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	454 550 332.38	454 550 332.38
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	84 656 000.00	238 988 582.83	454 550 332.38	778 194 915.21
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	454 550 332.38	454 550 332.38
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	84 656 000.00	238 988 582.83	454 550 332.38	778 194 915.21

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	348235836.70	348235836.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348235836.70	348235836.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	348235836.70	348235836.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260593418.70	260593418.70
210101	Үндсэн цалин	176712830.70	176712830.70
210102	Нэмэгдэл	57648868.00	57648868.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4438793.00	4438793.00
210104	Урамшуулал	21792927.00	21792927.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34843000.00	34843000.00
210201	Тэтгэврийн даатгал	24414800.00	24414800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2607100.00	2607100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2085700.00	2085700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	521400.00	521400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5214000.00	5214000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23062580.00	23062580.00
210301	Гэрэл, цахилгаан	19549380.00	19549380.00
210303	Цэвэр, бохир ус	3513200.00	3513200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	580000.00	631000.00
210401	Бичиг хэрэг	123000.00	123000.00
210402	Тээвэр, шатахуун	61700.00	61700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	101 000.00	152 000.00
210404	Ном, хэвлэл	70 300.00	70 300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	224 000.00	224 000.00
2105	Нормативт зардал	22 952 838.00	22 952 838.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3 485 874.00	3 485 874.00
210502	Хоол, хүнс	18 463 264.00	18 463 264.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 003 700.00	1 003 700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4 643 400.00	4 643 400.00
210604	Урсгал засвар	4 643 400.00	4 643 400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	544 000.00	544 000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112 000.00	112 000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432 000.00	432 000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1 016 600.00	965 600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 016 600.00	965 600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	363 614 400.00	348 235 836.70
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	333 412 200.00	320 529 856.70
131001	Улсын төсвөөс санхүүжих	333 412 200.00	320 529 856.70
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30 202 200.00	27 705 980.00
132001	Орон нутгийн төсвөөс	30 202 200.00	27 705 980.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	150.00	150.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	150.00	150.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	150.00	150.00

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Тайлант онд нэмэлт дансаар орлого зардлын гүйлгээ хийгдээгүй болно.

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг шууд захирагч танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нормативт зардал/хоол/ е баримтын бүрдүүлэлт, унаа, хоол, түлшний хөнгөлөлтийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 19 -наас 2021 оны 01 дүгээр сарын 21-ны хооронд Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал аудитор Д.Хишгээ хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ:

Тус цэцэрлэг нь 2020 онд “Бага насны хүүхэд бүр бие, оюун ухаан, сэтгэлээр эрүүл өсөн бойжих, өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ хөгжих, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэхэд зорилт дэвшүүлэн дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.. Үүнд:

- Хүүхэд эрүүл бие бялдартай, биеийн хөдөлгөөнөө зохицуулан аливаа үйл ажиллагаанд идэвх сонирхолтой оролцож, болзошгүй осол гэмтлээс сэргийлэх, эрүүл амьдрах дадалтай болох:
- Хүүхэд өөрийн болон хүмүүсийн сэтгэл хөдлөл, зан байдлыг танин мэдэх, ойлгох, сэтгэлийн хөдөлгөөн, зан, үйл, харилцаагаа эергээр зохицуулан хүмүүстэй хүндэтгэлтэй харилцах:
- Хүүхэд өөртөө итгэлтэй, эерэг зан чанартай, тууштай, суралцах сонирхолтой байх:
- Хүүхэд хүмүүсийг сонсож, тэдэнтэй ярилцаж, мэдээлэл солилцох дуртай, санаа бодол, мэдрэмж, мэдлэг төсөөллөө хэл яриагаар илэрхийлэх:
- Хүүхэд бодит амьдралд тулгуурлаж, математикийн энгийн төсөөлөлд суралцах, түүнд сонирхолтой байж, өдөр тутам хэрэглэдэг байх:
- Хүрээлэн буй байгаль, нийгмийн орчныг сонирхож, тэдгээрийн учир шалтгаан, харилцан хамаарлыг өдөр тутмын амьдралаас ойлгож, танин мэдэх, орчинтойгоо зохистой харьцдаг байх: Хүүхэд дүрслэх урлаг, хөгжмийг сонирхож, таашааж, уран сэтгэмжтэй, урлагийн үйлд бүтээлчээр оролцдог

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Тус байгууллага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна. Тухайн оны шилэн дансны

мэдээллээ хугацаандаа оруулж улирал тутам тайлангаа илгээсэн тул зөрчил илрээгүй байна.

Сар бүр Жаргалант сумын төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэлэхэд 99-100%-аар дүгнэгдсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 314737,0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3147,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 2 хувиар 8917.3 мянган төгрөгөөр тооцлоо.

Алдааны дүн материаллаг бус /эрсдэл бага / үр нөлөөгүй цар тахлын үед ажилчдаа олгосон унаа, хоол, түлшний урамшуулал нь олон хүнийг хамруулсан учраас дүн өндөр гарч буй учраас аудитын төлөвлөлтийн үед сонгосон МБ-түвшинг 2 хувь болгон өөрчилсөн.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11738.2 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	
			Дүн	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө				
Авлага	36.00		36.00	100.0%
Урьдчилгаа			-	
Бараа материал	37 575.70	45 237.70	- 7 662.00	-20.4%
Үндсэн хөрөнгө	740 583.20	721 218.90	19 364.30	2.6%
Нийт хөрөнгө	778 194.90	766 456.60	11 738.30	0.82
Өр төлбөр			-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	778 194.90	766 456.70	11 738.20	1.5%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	778 194.90	766 456.70	11 738.20	1.5%

Авлага дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж 36.0 мянган төгрөгөөр буурсан нь татвар ндш-ын тооцооллоос зөрүүгээр үүссэн авлагыг барагдуулжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 45237.7 мянган төгрөг болж 7662.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 32000.6 мянган төгрөгийн орлого авч, 24338.6 мянган төгрөгний бараа материал зарцуулж, хандиваар Тайваны гэр бүлийг дэмжих сангаас 1412.5 мянган төгрөгийн хөнжил гудас, углаа дэвсээ авсан.

Эм боох материалын үлдэгдэл 1493.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь Жаргалант сумын Засаг даргын 2020-03-20-ны № 1/288 тоот албан бичиг/Жаргалант сумын ЕБС, СӨБ-ыг гамшгаас хамгаалах аюулгүй байдлын нөөцийн жишиг жагсаалт/, 2020-03-13-ны өдрийн

Жаргалант сумын онцгой комиссын хурлын шийдвэр № 05 шийдвэрээр эм боох материалын зардал дээр нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

Хүнсний материалын үлдэгдэл 447,2 мянган төгрөг байгаа нь бөгөөд МУ-ын боловсрол шинжлэх ухааны сайдын 2020-11-27-ны А/162 тоот тушаалаар тус цэцэрлэг хоол хүнс тэжээлийн дутагдалд өртөх эрсдэл бүхий өөрийн цэцэрлэгт хамрагддаг 5 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн орсон 22311 төгрөгийн нэг бүрийн үнэтэй 1003.9 мянган төгрөгийн үнэ бүхий хоол хүнсийг 45 хүүхдэд олгосон байна.

Бичиг хэрэг 662.3, аж ахуйн материал 94.9, бусад хангамжийн материал БҮТЭЗ 38305.3 мянган төгрөгний үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 721218.9 мянган төгрөг болж өмнөх оноос 27115.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1600.0 төгрөгөөр эмнэлгийн сейф, хөргөгч худалдан авч, 3499.0 мянган төгрөгөөр өссөн БСУГ-аас 2 ш нөөтбүүк хөрөнгө оруулалтаар, Жаргалант сумын ОНХСангаас тус цэцэрлэгийн гадна машины зогсоол хийсэн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэж авсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 23499.0 мянган хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны хуримтлагдсан элэгдэл оны эхэнд 80403.8 мянган төгрөг байснаас тайлант онд 46480.1 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна. Тус байгууллага өр төлбөр дансны үлдэгдэлгүй. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 766456.7 мянган төгрөг болж 11738.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2020-ны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 50663.8 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 29771.4 мянган төгрөгийн орлого нь өмнөх оноос тусгай зориулалтын болон орон нутгийн санхүүгийн дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	ЗӨРҮҮ	ХУВЬ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339 914.0	390 577.8	-50663.8	41.2
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5 671.0	26 963.4	-21292.4	
Бусад орлого	400.0	-	400.0	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	333 843.0	363 614.4	-29771.4	58.8
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	301 691.5	333 412.2	-31720.7	
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	-	30 202.2	-30202.2	
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5 157.4	-	5157.4	

Нийт зардал өмнөх оноос 35533.0 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 37561.2, нийгмийн даатгалын шимтгэл 4740.4, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 2361.6, эд хогшил, урсгал зардал 1520.8, бараа үйлчилгээний бусад зардал 17487.5, буцаан төвлөрүүлсэн 15130.8 мянган төгрөгөөр тус зардлууд байна.

Энэ нь өмнөх оноос цалин хөлсний зардалд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл шинээр тооцогдон олгогдсон, төсвийн хэмнэлтээс буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	351 114.8	386 647.8	-35533.0	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224 436.8	261 997.9	-37561.2	105.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28 698.1	33 438.5	-4740.4	13.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21 254.2	18 892.6	2361.6	-6.6
Хангамж, бараа материалын зардал	695.1	356.0	339.1	-1.0

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	ЗӨРҮҮ
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	363 614.4	348 235.8	15 378.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260 703.2	260 593.4	109.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35 195.0	34 843.0	352.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25 558.8	23 062.6	2 496.2
Хангамж, бараа материалын зардал	580.0	631.0	- 51.0
Нормативт зардал	35 214.4	22 952.8	12 261.6
Эд хогшил, урсгал засварын зардал	4 643.4	4 643.4	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	575.6	544.0	31.6
Бараа үйлчилгээний бусад зардал	1 016.6	965.6	51.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	363 614.4	348 235.8	15 378.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	333 412.2	320 529.9	12 882.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30 202.2	27 706.0	2 496.2
Нормативт зардал	48 800.7	20 616.3	28184.4
Эд хогшил, урсгал засварын зардал	5 199.2	3 678.4	1520.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432.0	544.0	-112.0
Бараа үйлчилгээний бусад зардал	14 258.1	31 745.6	-17487.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7 340.8	15 378.6	-8037.8
Бусад урсгал шилжүүлэг	5 557.4	-	5557.4
Төвлөрүүлэх шилжүүлэг	1 783.4	15 378.6	-13595.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(11 200.8)	3 930.0	-15130.8
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(11 200.8)	3 930.0	-15130.8

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан ямар нэгэн өөрчлөлт байхгүй.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 400152.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 400152.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төсөлд 2020 онд хасах тодотгол хийж 36538.5 мянган төгрөгөөр бууруулж 363614.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасан Коронавируст халдвар/ ковид -19/ цар тахалтай холбоотой анх батлагдсан төсвөөс хасаж тодотгол хийсэн 36538.5, оны сүүлчээр зарцуулаагүй үлдэгдэл санхүүгийн дэмжлэгээ буцаан төвлөрүүлсэн 15378.5 бүгд 51917.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зарцуулаагүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 363614.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 333412.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүгийн дэмжлэгээр, 30202.2 орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 363614.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 363614.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 348235.8 мянган төгрөгийг зарцуулж 15378.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 348235.8 мянган төгрөг буюу 95.7 хувьтай буюу 15378.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 109.8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь тухайн онд ковид-19 буюу цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа

хэдэн сараар хүүхэд авахгүй хойшилсон, энэ үед багш, туслах багш нарын илүү цагийн хөлс олгоогүй, жирэмсэн болон хүүхдээ асарч байгаа багшийн оронд түр ажиллаж байсан багшийг амрааж цалинг хэмнэсэн зэргээс шалтгаалжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл:352.0 мянган төгрөгөөр хэмнэсэн нь анх төсөв төлөвлөхдөө нэг хувийн илүү тооцоололт хийгдсэн тул тухайн санд үлдээн буцаан төвлөрүүлсэн байна.

Байр ашиглалттай холбоотой зардал 2496.2, Хоол хүнс 12261.6, бараа үйлчилгээний бусад зардал 51.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь Ковид-19 буюу цар тахалтай холбоотойгоор цэцэрлэгийн үйл ажиллагаа зарим сард ажиллаагүй, зарим сард хагас ажилласан, тайлант онд томилолтоор багш ажилтан яваагүй, зуны улиралд ээлжийн бүлэг ажиллаагүй зэрэгтэй холбоотой байна.

Шинээр төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд нийт зөрүүний 27.8 хувь буюу 13930.7 мянган төгрөг байна.

Оны эцэст Коронавируст халдвар ковид-19 цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой өмнөх оноос өссөн цалингийн өсөлтийн 28.3 хувь буюу 8643.6 мянган төгрөгийг түлшний хөнгөлөлтөд олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд тус байгууллагын нэмэлт дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан. 151 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6698.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6698.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил байхгүй.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6698.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараах 2 асуудлыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангийн үеэр анхаарал хандуулж дахин хянаж хэрэгжилтийг нэгтгэн хянах шаардлагатай байна. Үүнд:

- 2020-09-03-ны өдрийн А/483 тоот Ховд аймгийн Засаг даргын захирамжаар Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн анги танхим байрны дотоод орчны агаарын чанарыг сайжруулан дэвшилтэт технологи болох “Окфил” агаар шүүгчийг суулгах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Тус цэцэрлэгт 30 ширхгийг 6 ангид 3390.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн,
- 2020 оны 02 сарын 18-ны Ховд аймгийн Засаг даргын А/107 тоот захирамжаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө гаргах тухай захирамжаар Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 380.0 мянган төгрөгийн маск нийлүүлэх гэрээ хийж Буянт үйлийн шим ХХК-д шилжүүлсэн
- БСУГ-аас хөрөнгө оруулалтаар Dell latitude 3400 CTO Business model 2 ширхэг нөтөбүүкийг нэг бүрийг 1749500 төгрөгөөр 3499,0 төгрөгөөр бэлтгэсэн зэрэг асуудлуудыг аймгийн ТЕЗ-ын нэгтгэсэн тайлангаар авч үзэх шаардлагатай байна.
-

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нормативт зардал /Хоол /

Илрүүлэлт: Тайлант онд нийт 7013 хүүхэд өдөрт 16995.6 мянган төгрөгний хоолонд зарцуулж нэг хүүхдэд 2423.0 төгрөг ноогдож, норматив /2475/ зардлаас 51.6 төгрөгөөр дутуу зарцуулж нийт 361604 төгрөгний хоол дутуу олгосон байна Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУЗГ-ын тогтоол зөрчсөн байна.

- 1.1. *Эрсдэл: хууль, дүрэм, журам зөрчигдөх*
- 1.2. *Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай” тогтоолыг мөрдөх*
- 1.3. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвшөөрч байна.*

И-баримтын бүрдүүлэлт

2.1. *Илрүүлэлт:* Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу байна.

2.2. *Эрсдэл:* тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах

2.3. *Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах

3.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*Зөвшөөрсөн

Цалингийн зардал /хоол, унаа, түлшний хөнгөлөлт

3.1. *Илрүүлэлт:*

Оны эцэст Коронавируст халдвар ковид-19-ын цар тахалтай холбоотой үйл ажиллагаа тасалдсанаас батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 6337.0 мянган төгрөгийн унаа хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 23 албан хаагчдад олгосон байна.

3.2. *Эрсдэл:* төсвийн хөрөнгийг буруу зарцуулах, эдийн засгийн ангилал зөрчих, төсвийн төлөвлөлт буруу төлөвлөх

3.3. *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллах

3.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			XOA-2021/11/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны нормативт зардлаас нэг хүүдэд 51.6 мянган төгрөгөөр дутуу олгосон.	361.6	Зөвлөмж	Захирал	Б.Оюунчимэг
2	Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу		Зөвлөмж	Захирал	Б.Оюунчимэг
3	Батлагдсан төсөвт зардал хэмнэсэнтэй холбоотой 8643.6 мянган төгрөгийг унаа	6337.0	Зөвлөмж	Захирал	Б.Оюунчимэг

	хоолны хөнгөлөлтийг нэр бүхий 23 албан хаагчдад олгосон байна.				
ДҮН		6698.6			

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР Огноо:2021. 02.23

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН Огноо:2021.02.23

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР АУДИТ ХХК-НЫ ХОВД АЙМАГ ДАХЬ
САЛБАРЫН ЗАХИРАЛ, АУДИТОР Д.ХИШГЭЭ

Огноо:2021. 02.23